

Төлөвлөгөө хянасан:

Сайд
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн ерөнхийлөн захирагч

Л.Халтар
Л.ХАЛТАР

(гарын үсэг)

(2021.12.30) 5319487 СБА7589

Төлөвлөгөө баталсан:

Далайн захиргааны дарга
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн шууд захирагч

Б.Биндэръяа
Б.БИНДЭРЪЯА

(гарын үсэг)

(2021.12.30)
ТУ32195 X 5282818

ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ – ТУСГАЙ ЧИГ ҮҮРЭГ						
ЗОРИЛТ 1.1 УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон Засгийн газрын 2019 оны 358 дугаар тогтоолоор батлагдсан Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт тусгагдсан далай, усан замын тээврийн салбарын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх						
1.1.1	Архангай аймгийн Өгийнуурт усан замын	Барилгын ажлыг хүлээн авсан байна.	Архангай аймгийн Өгийнуур суманд газрын асуудлыг орон нутгийн	1-р улиралд: Барилгын ажил сонгон	I-IV улирал	УЗТБХА


	тээврийн "Хяналтын пост"-ыг байгуулах		байгууллагаар шийдвэрлүүлсэн.	шалгаруулалтыг зохион байгуулсан байна. 2-р улиралд: Барилгын ажлыг эхлүүлсэн байна. 3-4-р улиралд: Барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан байна.		
1.1.2	Өгий нуурт эргүүл хяналтыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зориулалтын завийг шинээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна.	Шинээр	1-р улиралд: Тендерийн баримт бичгийг боловсруулж, зарласан байна. 2-р улиралд: Нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. 3-4-р улиралд: Нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлд хяналт тавьсан байна.	I-IV улирал	УЗТБХА
1.1.3	Хуурай боомтын талаар хийсэн судалгаануудыг эмхтгэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Хуурай боомтыг хөгжүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.	Хуурай боомтын тухай хэлэлцээрт нэгдэн орсон гишүүн орнуудын туршлагыг цахимаар судалж, судалгааг 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 1/281 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.	2-р улиралд: Далайн захиргаанаас хийсэн хуурай боомтын талаарх судалгаануудыг гарын авлага болгон хэвлүүлсэн байна. 4-р улиралд: Хуурай боомтыг хөгжүүлэх талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна.	I-IV улирал	ДТБХАХА
1.1.4	Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүнийг гуравдагч оронд гаргахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Боомтын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, холбогдох хүмүүстэй уулзалт хийх ажлыг зохион байгуулсан байна.	Монгол Улсын экспортын коксжих нүүрсийг ОХУ-ын Восточный боомт болон БНХАУ-ын Жинжоу, Цаофэйдянь далайн боомт хүргэх эдийн засгийн тооцоо судалгааг хийж гүйцэтгэсэн.	2-р улиралд: Бусад боломжит боомтуудтай хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэл тус бүрээр санал боловсруулж, ЗТХЯ-д хүргүүлсэн байна. 4-р улиралд: Хамтын ажиллагааг эхлүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.	I-IV улиралд	ДТБХАХА

МОНГОЛ УЛСЫН
САНД ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ... ОНЫ ... ДУГААР ТУШААЛ

ЭХ ХУВЬ


Санд Төрийн нарийн бичгийн даргын ... оны ... дугаар тушаал

1.1.5	Монгол Улсын импортын бараа бүтээгдэхүүнийг далайн боомтоор дамжуулан тээвэрлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлийг хөнгөвчлөхөд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх	МТЗНХ-той байгуулсан Санамж бичгийн төлөвлөгөөг шинэчлэн баталж, үе шаттай хэрэгжүүлж ажиллана.	МТЗНХ-той 2018 онд байгуулсан Санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах төлөвлөгөөний хугацаа дууссан.	2-р улиралд: Хамтын ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна. 4-р улиралд: Төлөвлөгөөг үе шаттай хэрэгжүүлж ажилласан байна.	I-IV улирал	ДТБАХА
1.1.6	Усан замын тээврийн хэрэгслээр аюултай ачаа тээвэрлэх дүрмийг шинэчлэн боловсруулах	Журмыг шинэчлэн боловсруулсан байна.	Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 45 дугаар тушаалаар батлагдсан.	2-р улиралд: Журмын төслийг шинэчлэн боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-II улирал	УЗТБХА
1.1.7	Усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журмыг шинэчлэн боловсруулах	Журмыг шинэчлэн боловсруулсан байна.	Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын 2005 оны 23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан.	2-р улиралд: Журмын төслийг шинэчлэн боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-II улирал	УЗТБХА
Засгийн газрын 2019 оны 358 дугаар тогтоол Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 231 дүгээр тушаалаар батлагдсан “Зам, тээврийн салбарын стратегийн зорилт”-ын 2.2.1.1. Салбарын хүний нөөцийн бодлого, төсөл, хөтөлбөр, боловсруулах, хүний нөөцийн сургалтыг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдамжаар хангах.						
1.1.8	Гадаадын их, дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах	Монгол Улсын далайн тээврийн салбарын боловсон хүчний тоог нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авсан байна.	Далайн тээврийн салбарт дипломын боловсрол эзэмшсэн нийт 14 хүн тус салбарт ажиллаж байна.	1-р улиралд: Салбарын боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх талаар судалгаа хийж, 2022 оны сургалтын хөтөлбөрийг батлуулсан байна. 2-4-р улиралд: Салбарын их, дээд сургууль, сургалтын төвүүдэд боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр санал хүргүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	I-IV улирал	ЗУХ




1.1.9	“Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах	Усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх асуудлаар холбогдох сургалтын байгууллагуудтай хамтран ажилласан байна.	Усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн ур чадварыг үнэлэх ажлыг 2021 онд ХНХЯ-ны МБСҮМАЗТ-тэй хамтран Архангай, Хөвсгөл аймагт зохион байгуулсан ба үнэлгээнд нийт 95 иргэнийг хамруулж, үнэмлэх олгосон.	2-р улиралд: Усан замын тээврийн хэрэгслийн цахим бүртгэл мэдээллийн санд сайжруулалт хийж, жолоочийн бүртгэлийг нэмж оруулсан байна. 4-р улиралд: Усан замын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх асуудлаар холбогдох сургалтын байгууллагуудтай хамтран ажилласан байна.	I-IV улирал	УЗТБХА
Засгийн газрын 2019 оны 358 дугаар тогтоол Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 231 дүгээр тушаалаар батлагдсан “Зам, тээврийн салбарын стратегийн зорилт”-ын 2.2.4.3. Усан замын тээврийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл хөтлөх, зохицуулах						
1.1.10	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийг өргөжүүлэх	Хөлөг онгоцны бүртгэлийн агентыг шинээр томилон ажиллуулсан байна.	2021 онд хөлөг онгоц бүртгэлийн 4 агенттай гэрээ байгуулсан.	2-р улиралд: Хөлөг онгоцны бүртгэлийн зуучлагч 2 агентыг судалж, хамтран ажиллах гэрээний нөхцөлийг тохиролцсон байна. 4-р улиралд: Гэрээ байгуулж, хамтын ажиллагааг эхлүүлсэн байна.	I-IV улирал	ХОБХА
1.1.11	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд тавих хяналтын тогтолцоог сайжруулах	Бүртгэлтэй хөлөг онгоцтой сансрын холбоогоор шууд холбогдох ажлын хүрээнд ослын дохио хүлээн авах төхөөрөмжийн үнийн судалгааг хийж, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг	2021 онд сансрын холбооны төхөөрөмжийг худалдан авч, ашиглалтад оруулсан.	2-р улиралд: Хөлөг онгоцноос ослын дохио хүлээн авах төхөөрөмжийн үнийн судалгааг хийж, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулсан байна.	I-II улирал	ХОБХА


*Боолетуудад агентуудыг сонгон
ажиллуулах*




		боловсруулсан байна.				
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
ЗОРИЛТ 2.1 Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох						
Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.2. дэх заалт, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл						
2.1.1	Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар соёрхон батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн.	1-4-р улиралд: Хуулийн төслийг боловсруулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, УИХ-аар батлуулахад мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.	I-IV улирал	ЗУХ, ХОБХА, ДТБАХА
2.1.2	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Тайланг боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	Тайланг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хорооноос гаргасан асуулгын дагуу /англи, монгол хэл дээр/ боловсруулан 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 1/82 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.	2-р улирал: “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хорооноос гаргасан асуулгын дагуу англи, монгол хэл дээр боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	II улирал	ЗУХ, ХОБХА
ЗОРИЛТ 2.2 Далбааны эзэн улсын үүрэг, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, Монголын хөлөг онгоцны бүртгэлийн чанарыг сайжруулах, өргөжүүлэх						
2.2.1	Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн явуулж хөлөг онгоцны бүртгэлийн баримт бичгийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох	Бүртгэлтэй хөлөг онгоцны бүртгэлийн бичиг баримтын нэгдсэн сан үүсгэсэн байна.	180 хөлөг онгоцны бүртгэлийн түүх шинээр үүсгэсэн.	1-р улиралд: Бүртгэлийн түүхийг цэгцлэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хадгалах нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна. 2-р улиралд: Хөлөг онгоцны бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан байна.	I-IV улирал	ХОБХА, ЗУХ




				3-р улиралд: цуж᠙ Хөлөг онгоцны бүртгэлийн программ хангамжийг сайжруулан хөлөг онгоцны мэдээллийн цахим архивыг баяжуулсан байна. 4-р улиралд: Хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгох боломжийг судалсан байна.		
2.2.2	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоцонд бүртгэлтэй хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалт явуулах	5 хүртэлх хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалт хийсэн байна.	БНСУ-ын Бусан боомтод 1, БНСВУ-ын Хо Чи Мин Сити боомтод 1 хөлөг онгоц дээр гэрээт хянан шалгагчаар тус тус үзлэг шалгалт явуулсан.	2-р улиралд: Гадаадын болон дотоодын хянан шалгагч томилон ажиллуулж, 2 хөлөг онгоцонд үзлэг шалгалт хийсэн байна. 4-р улиралд: Гадаадын болон дотоодын хянан шалгагч томилон ажиллуулж, 3 хөлөг онгоцонд үзлэг шалгалт хийсэн байна.	I-IV улирал	ХОБХА
ЗОРИЛТ 2.3 Байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэхэд анхаарч, эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэд хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах						
2.3.1	Гол, мөрөнд зориулсан гатлага онгоцонд тавигдах ерөнхий шаардлагын төслийг боловсруулах	Ерөнхий шаардлагын төслийг боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Усан замын тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах ерөнхий шаардлагын төслийг боловсруулах, батлуулах ажлыг "Төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн стандартчиллын техникийн хорооны /ТХ-33/ 2022-2023 оны ажлын төлөвлөгөө"-нд тусгуулах тухай саналыг ЗТХЯ-нд хүргүүлсэн.	2-р улиралд: Стандартын төслийг боловсруулах судалгааны ажлыг эхлүүлсэн байна. 4-р улиралд: Ерөнхий шаардлагын төслийг боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-IV улирал	УЗТБХА
2.3.2	Усан замын тээврийн хэрэгслийг угсрахад	Усан замын тээврийн	Шинээр	3-р улиралд:	I-III улирал	УЗТБХА




	тавигдах шаардлагын төслийг боловсруулах	хэрэгслийг угсрахад тавигдах шаардлагын төслийг боловсруулсан байна.		Төслийг боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.		
2.3.3	Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллах талаар орон нутгийн холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах	Орон нутгийн байгууллагуудыг бүрэн хамруулах талаар шаардлагатай арга хэмжээ авч ажилласан байна.	Далайн захиргаанаас "Хийлдэг завь тоглоом биш" аяныг зохион байгуулж байгаа бөгөөд уг аяныг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангаж, хамтран ажиллахаар төлөвлөөд байна.	2-р улиралд: Орон нутгийн байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан байна.	II улирал	УЗТБХА
2.3.4	Усан замын тээврийн хэрэгслийн 2022 оны техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах	Техникийн хяналтын үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулж, тайлан мэдээг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	"Усан замын тээврийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг, тооллогыг жил бүр зохион байгуулж байна.	2-р улиралд: Техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлуудыг хангасан байна. 3-р улиралд: Техникийн хяналтын үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулж, тайлан мэдээг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	II-III улирал	УЗТБХА
2.3.5	Усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, тайланг ЗТХЯ-ны ХШУДАГ-т хүргүүлсэн байна.	МХЕГ-аас Далайн захиргааны мэргэжилтэнд улсын байцаагчийн эрхийг олгосон бөгөөд эдгээр улсын байцаагчид нь усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль,	2-р улиралд: Хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө, удирдамжийг баталсан байна. 3-р улиралд: Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, тайланг ЗТХЯ-ны ХШУДАГ-т хүргүүлсэн байна.	II-III улирал	УЗТБХА




			тогтоомжийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа талаар төлөвлөгөөт хяналт шалгалтыг жил бүр хийж гүйцэтгэж байна.			
2.3.6	Онцгой байдлын Ерөнхий газартай байгуулсан хамтын ажиллагааны Санамж бичгийн хүрээнд усан замын тээврийн аюулгүй ажиллагаанд тавих хяналтыг хамтран хэрэгжүүлэх	Зарим усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг болон завьт эргүүл хяналтыг хамтран хэрэгжүүлсэн байна	ОБЕГ-тай 2015 онд хамтын ажиллагааны Санамж бичгийг байгуулсан бөгөөд уг санамж бичгийн хүрээнд усан замын тээврийн аюулгүй байдалд тавих хяналт, урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр батлан биелэлтийг ханган ажилладаг.	2-р улиралд: 2022 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан байна. 3-р улиралд: Төлөвлөгөөний дагуу ажиллаж, биелэлтийг дүгнэж ажилласан байна.	II-III улирал	УЗТБХА
ЗОРИЛТ 2.4. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх.						
2.4.1	Олон улсын далайн байгууллага болон бусад олон улсын байгууллагын олон улсын гэрээ, конвенц, бусад холбогдох баримт бичиг болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд Монгол Улс нэгдэн орох эсэх талаар санал боловсруулан холбогдох мэдээлэл бэлтгэх	Олон улсын гэрээ, конвенц болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох эсэх талаарх шаардлагыг судалж, мэдээллийг бэлтгэсэн байна.	Байгууллагын дүрмийн 4.1.4 дэх заалт	2-р улиралд: Олон улсын гэрээ, конвенц, болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох эсэх талаар судалсан байна. 4-р улиралд: Нэгдэн орох шаардлагатай олон улсын гэрээ, конвенц, болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтийг орчуулж, ГХЯ-аар хянан баталгаажуулах ажлыг ЗТХЯ-нд уламжилж, хуулийн төслийн үзэл баримтлал, холбогдох танилцуулгын хамт хүргүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ, ХОБХА, ДТБХА
2.4.2	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцны	Олон улсын гэрээ конвенцын	"FULCRUM MARINE SERVICES" компанитай гэрээ байгуулсан,	1-р улиралд: "IHS Markit" болон бусад ижил төстэй хяналтын системийн	I-IV улирал	ХОБХА




	байршлыг тогтоох, алсын зайнаас хянах талаар олон улсын гэрээ конвенцын шаардлагыг хангаж ажиллах	шаардлагыг хангасан байна.	"Marine Traffic" системийг ашиглаж байна.	үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын системийг ашиглах талаар үнийн судалгаа хийсэн байна. 2-р улиралд: Сонгосон байгууллагатай хяналтын системийг ашиглах гэрээ байгуулсан байна. 3-4-р улиралд: Тус хяналтын системийг ашиглан бүртгэлтэй байгаа бүх хөлөг онгоцонд эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.		
ЗОРИЛТ 2.5 БНСУ-тай хамтран далайн тээвэр эрхлэх боломжийг эрэлхийлэх						
2.5.1	Хөрш орнуудын боомтоос "Монгол-Саммок Ложистик" хамтарсан компаниар дамжуулан далайгаар гуравдагч оронд нүүрс тээвэрлэх бэлтгэл ажлыг хангах	2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	"Монгол-Саммок Ложистик" хамтарсан компанийн 2021-2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хамтран баталсан.	2-р улиралд: Туршилтын тээврийг зохион байгуулах ажлын даалгавар, холбогдох төсөв зардлын тооцоог боловсруулсан байна. 4-р улиралд: ТУЗ-ийн хурлыг хуралдуулж, хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцсэн байна.	I-IV улирал	ДТБАХА
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
ЗОРИЛТ 3.1 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах						
3.1.1	Далайн захиргааны бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг шинэчлэн батлуулах	Далайн захиргааны бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулахаар ЗТХЯ-нд	ОУДБ-аас хийсэн аудитын шалгалтаар нийт 18 зөрчил, 1 сануулга илэрснээс 12 зөрчилд нь хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлага тавьсан.	2-р улиралд: Далайн захиргааны бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг шинэчлэн батлуулах саналыг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-II улирал	ЗУХ




		хүргүүлсэн байна.				
3.1.2	Хөлөг онгоцны багийн гишүүний чадамжийг гэрчилсэн далайчны хөдөлмөрийн дэвтрийн /Seaman book/ загварыг боловсруулах	Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх Далайчны хөдөлмөрийн дэвтрийн загварыг гаргаж, ЗТХЯ-нд холбогдох материалын хамт хүргүүлсэн байх.	Шинээр	2-р улиралд: Холбогдох судалгааны ажлыг хийсэн байна. 4-р улиралд: Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх Далайчны хөдөлмөрийн дэвтрийн загварыг гаргаж, ЗТХЯ-нд холбогдох материалын хамт хүргүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ, ХОБХА
3.1.3	Хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүнд ажиллах үндэсний боловсон хүчнийг олон улсын эрх зүйд нийцүүлэн Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцон дээр ажиллуулах боломжийг судлах	Бэлтгэгдсэн үндэсний боловсон хүчнийг Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцон дээр ажиллуулах боломжийг эрэлхийлж ажилласан байна.	Байгууллагын дүрмийн 4.1.5 дах заалт	1-4-р улирал: Бэлтгэгдсэн үндэсний боловсон хүчнийг Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоцон дээр ажиллуулах боломжийг эрэлхийлж ажилласан байна.	I-IV улирал	ХОБХА, ЗУХ
3.1.4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах	Хуулийн хэрэгжилтийг хангаж, ЗТХЯ-нд тайланг хүргүүлсэн байна	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Орон тооны бус дэд зөвлөл”, Зам, тээврийн хөгжлийн яамны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл”-ийн 2020 онд	4-р улиралд: Хуулийн хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	IV улирал	ЗУХ




			авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ЗТХЯ-нд тайлагнасан.			
3.1.5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах	ХАБЭА-н тухай хууль, ХАБЭА-н үндэсний тавдахь хөтөлбөр, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны "Сахилга хариуцлага-Хөдөлмөрийн аюулгүй байдлын жил болгон зарлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	Далайн захиргааны ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөө батлагдсан.	2-р улиралд: Хуулийн хэрэгжилтийн тайланг хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна. 4-р улиралд: Хуулийн хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.6	Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Холбогдох сургалтад ажилтнуудыг хамруулсан байна.	АТГ-аас зохион байгуулсан сургалтуудад нийт ажилтнуудыг хамруулж ирсэн ба Далайн захиргаанаас авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган, АТГ-т тайлагнаж ажилласан.	1-р улиралд: Авлигын эсрэг үйл ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг баталсан байна. 2-р улиралд: Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг эхний хагас жилийн байдлаар гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. 4-р улиралд: Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг жилийн эцсийн байдлаар	IV улирал	ЗУХ




				гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалт хийж, үр дүнг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.		
3.1.7	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах	Хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Зам, тээврийн салбарт "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж, жил бүр ЗТХЯ-нд тайлагнаж хэвшсэн.	1-р улиралд: Зам, тээврийн салбарт "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна. 2-3-р улиралд: Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, холбогдох сургалтыг зохион байгуулсан байна. 4-р улиралд: Хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	IV улирал	ДТБАХА, ЗУХ
3.1.8	Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах зорилгоор Хатгал тосгон дахь усан зогсоолын орчмын хог хаягдлыг бууруулах чиглэлээр олон нийтэд чиглэсэн сурталчилгаа хийх, эрэг дагуух хогийг цэвэрлэх нэгдсэн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	Хөвсгөл нуурын Хатгал тосгоны усан замын тээврийн зогсоолын орчмын хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан байна	Далайн захиргааны хэлтэс, албадуудын мэргэжилтнүүд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд нуурын эргийн дагуух хог, хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг 2021 онд зохион байгуулсан.	3-р улиралд: Нэгдсэн арга хэмжээг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулж, тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	III улирал	ЗУХ, ДТБАХА, УЗТБХА
3.1.9	Ажилтнуудыг урамшуулах, салбарын шагналд тодорхойлж, шагнуулах	Тухайн ажилтныг зохих шагналд	Ажлын үр бүтээмжтэй, бусдыгаа манлайлж ажилласан ажилтнуудыг	4-р улиралд: Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үр дүнг дүгнэж, тухайн ажилтныг шагнуулах саналыг байгууллага,	IV улирал	ЗУХ



	саналыг холбогдох яам, байгууллагад хүргүүлэх	тодорхойлсон байна	холбогдох шагналд тодорхойлж, шагнуулах асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулдаг.	хамт олны саналаар дэмжсэн тохиолдолд зохих шагналд тодорхойлсон байна.		
3.1.10	Хүний нөөцийн удирдлагатай холбоотой нийтлэг үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, ээлжийн амралтын хуваарь гаргах, ажлын үнэмлэх олгох, бүртгэл, судалгааг хөтлөх зэрэг хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлэх	Хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлсэн байна	Тогтмол гүйцэтгэдэг ажил үйлчилгээ	2-р улиралд: Далайн захиргааны бүтэц, орон тооны хязгаар, дүрмийг шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор ажлын байрны зураг авалтыг эрх бүхий байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн байна. 4-р улиралд: Хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлж ажилласан байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.11	Ажилтнуудын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Далайн захиргааны ажилтнуудын нийгмийн баталгааны хөтөлбөр 2020 онд батлагдсан.	2-р улирал: Ажилтнуудын нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчлэн баталсан байна. 4-р улиралд: Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.12	Сайдын шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах	Үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан байна	Сайдын шуурхай хуралдаанаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнаж, дүгнүүлж хэвшсэн.	1-4-р улиралд: Үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр ЗТХЯ-нд тайлагнаж ажилласан байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.13	Хууль, тогтоомж, удирдах дээд байгууллагын тогтоол, тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах	Хэрэгжилтийг ЗТХЯ-нд хугацаанд нь тайлагнасан байна	Хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж, дүгнүүлж хэвшсэн.	1-4-р улиралд: Хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ




3.1.14	Сайд болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах	Хэрэгжилтийг ЗТХЯ-нд хугацаанд нь тайлагнасан байна	Хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж, дүгнүүлж хэвшсэн.	1-4-р улиралд: Хэрэгжилтийн тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.15	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн өргөдөл, гомдлыг цаг хугацаанд нь шийдвэрлэж, хэрэгжилтэд хяналт тавих	Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажиллана	2021 онд байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдээс гомдол, гомдол ирээгүй	1-4-р улиралд: Иргэдийн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.16	Байгууллагын албан хэрэг хөтлөлтийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулж, баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтөлсөн байна.	Тогтмол гүйцэтгэдэг ажил үйлчилгээ	1-4-р улиралд: Албан хэрэг хөтлөлтийг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулсан байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.17	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдүүлж ажиллах, зөвлөмжөөр хангах	2021 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалт батлагдаж, хадгаламжийн нэгж бүрдүүлсэн байна.	Тогтмол гүйцэтгэдэг ажил үйлчилгээ	2-р улиралд: Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталсан байна. 4-р улиралд: Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэн өгсөн байна.	I-IV улирал	ЗУХ
3.1.18	Гамшгаас хамгаалах хуулийн дагуу ажилтнуудын халдвар хамгааллыг сайжруулах, дархлаажуулах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлын үед байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн хэмжээнд зохион байгуулах	Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Далайн захиргааны даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 70 дугаар тушаалаар Бэлэн байдлын анги байгуулагдсан.	1-4-р улиралд: Ковид-19 цар тахалтай холбоотой гарсан тушаал, шийдвэрийн биелэлт, тайлан мэдээг ЗТХЯ-нд тухай бүр хүргүүлж ажилласан байна.	I-IV улирал	Бэлэн байдлын анги



ЗОРИЛТ 3.2 Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах


3.2.1	Усан замын тээврийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны статистик мэдээг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлэх	Усан замын тээвэрлэлтийн мэдээ, тайланг аж ахуйн нэгж, иргэдээс батлагдсан маягтаар авч, нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлсэн байна	Усан замын тээврийн тээвэрлэлтийн жилийн статистикийн тайлан мэдээний маягыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 158 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг маягтаар аж ахуйн нэгж, иргэдээс тээвэрлэлтийн мэдээг жил бүр нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлж ажилласан.	3, 4-р улиралд: Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс тайлан, мэдээ авах ажлыг зохион байгуулж, статистик мэдээг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлсэн байна	III-IV улирал	УЗТБХА
3.2.2	Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлэх	Мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна	Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажилладаг.	1-р улиралд: Мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна. 2-р улиралд: Мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна. 3-р улиралд: Мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна. 4-р улиралд: Мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-IV улирал	ХОБХА
3.2.3	Байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгон сурталчлан ажиллах	Цахим хуудсанд шинэ мэдээллийг байршуулсан байна.	2021 онд цахим хуудсыг шинэ мэдээллээр баяжуулан, Ил тод байдлын тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн.	1-4-р улиралд: Цахим хуудаст шинэ мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулж, тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.2.4	Далайн захиргааны 2022 оны цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөгөөний биелэлтийг ханган ажилласан байна.	Далайн захиргааны 2022 оны цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан.	1-4-р улиралд: Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг ЗТХЯ-нд улирал тутам хүргүүлсэн байна. ажилласан байна.	I-IV улирал	ЗУХ




3.2.5	Усан замын тээврийн хяналтад тээврийн хэрэгслийн байршил тогтоох GPS тоног төхөөрөмжийг ашиглах	Усан замын тээврийн хэрэгслийн хяналт сайжирсан байна.	Усан замын тээврийн хэрэгсэлд тохирох байршил тогтоогч төхөөрөмжийн судалгааг хийж, "TT TOOLS" ХХК-тай хяналтын систем ашиглах гэрээг байгуулсан.	3-р улиралд: Усан замын тээврийн хэрэгсэлд байршил тогтоох GPS төхөөрөмжийг суурилуулах талаар аж ахуйн нэгж, иргэдэд зохих шаардлага тавьж, ашиглалтад оруулсан байна.	III улирал	УЗТБХА
3.2.6	Зам, тээврийн салбарын энтерпрайз архитектур, төлөвлөлтийн нэгдсэн платформыг өөрсдийн үйл ажиллагаандаа иж бүрэн нэвтрүүлж, байгууллагынхаа энтерпрайз архитектурын чиг үүрэг, үйл ажиллагааг хариуцан ажиллах ажлын байр, албан тушаалтнуудыг тусгайлан томилж, эдгээр үйл ажиллагаагаа яамны бодлого, төлөвлөлттэй нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.	Хэрэгжилтийн байдлаар	Салбарын энтерпрайз архитектур, төлөвлөлтийн нэгдсэн платформын техникийн бэлтгэл байдал хангагдсан.	1-р улиралд: Байгууллагын бодлого, үйл ажиллагааны (бизнес) архитектор болон мэдээллийн технологийн чиг үүргийн архитекторуудыг тусгайлан томилж, холбогдох төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, платформ дахь өгөгдлийн каталог, мета загвар, баримтжуулалтын ажлыг дуусгасан байна. 2-р улиралд: Одоогийн архитектурыг тодорхойлж, эмзэг цэгийг тодруулах, үйл ажиллагааг үнэлэх, шинжлэх ажлыг хэрэгжүүлсэн байна. 3-р улиралд: Зорилтот архитектурт тавигдах шаардлагыг тодорхойлж (эрэлт хэрэгцээ, учрах эрсдэл, хугацаа, бизнес загвар, технологи, инновац), платформд бүртгэсэн байна. 4-р улиралд: Шилжилтийн архитектурын хувилбаруудыг бүрдүүлэн, үнэлж, зорилтот архитектураа эцэслэн тодорхойлж, шилжилтийн арга замаа тогтоон, холбогдох эрх зүй, бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХЭГ АЖЛИЙН
ЗХ ХҮВЬ


3.2.7	Байгууллагынхаа хэмжээнд кибер (мэдээллийн) аюулгүй байдлын эрсдэлийн иж бүрэн шинжилгээ, үнэлгээ хийлгэж, кибер (мэдээллийн) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, аюулгүй байдлын архитектураа төлөвлөх талаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийн байдлаар	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулсан.	1-р улиралд: Байгууллагын хэмжээнд кибер (мэдээллийн) аюулгүй байдлын эрсдэлийн иж бүрэн шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн байна. 2-р улиралд: Санал, зөвлөмжийн дагуу холбогдох үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна. 3-р улиралд: Аюулгүй байдлын зорилтот архитектураа тодорхойлсон байна. 4-р улиралд: Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо бий болгоход шаардлагатай эрх зүй, бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.2.8	Байгууллагынхаа нийт компьютерын 30-аас дээш хувийг албан ёсны байнгын ашиглах эрх (лиценз)-тэй үйлдлийн систем болон оффисын программ хангамжтай болгож, аюулгүй байдлыг хангах.	Ажлын явц, хувиар	Тухайн байгууллагын өнөөгийн түвшин	2-р улиралд: Зорилт, арга хэмжээний 50-аас багагүй хувийг хэрэгжүүлсэн байна. 4-р улиралд: Зорилт, арга хэмжээг 100% хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.2.9	Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ дээр суурилсан дэд систем, модуль хөгжүүлэлтүүдийг шуурхай хэрэгжүүлж, уг ажилд шаардлагатай платформ ашиглах эрх (лиценз)-ийг авч, өөрийн ажилтнуудыг энэ чиглэлээр сургаж мэргэшүүлэн, эдгээрт шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтаар нь	Хэрэгжилтийн байдлаар	Салбарын мэдээллийн нэгдсэн платформын техникийн бэлтгэл байдал хангагдсан.	1-р улиралд: Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ ашиглах эрх (лиценз)-ийг авсан байна. Уг платформ дээр суурилсан дэд систем, модуль хөгжүүлэх ажилтнуудаа томилж, энэ чиглэлээр сургаж мэргэшүүлсэн байна. 2-4-р улиралд: Платформ дээр суурилсан дэд систем, модуль хөгжүүлэлтийг хэрэгжүүлж, эдгээрийг яамны бодлого, төлөвлөлттэй нягт уялдуулж,	I-IV улирал	ЗУХ




	хангаж, энэ талаар яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаатай нягт уялдуулж, дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.			дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан байна.		
3.2.10	Байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн, албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.	Хэрэгжилтийн байдлаар	Тухайн байгууллагын өнөөгийн түвшин	1-р улиралд: Байгууллагынхаа удирдах ажилтан, албан хаагчдад тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн хэмжээнд нэвтрүүлж бусад ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна. 2-р улиралд: Тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог нэвтрүүлсэн байна. 3-4-р улиралд: Тоон гарын үсгийн хэрэглээг албан хэрэг хөтлөлтөд бүрэн ашигласан байна.	I-IV улирал	ЗУХ
3.2.11	Тухайн байгууллага өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд дэвшилтэд техник технологи, инновацын талаар туршлага судлах, хамтын ажиллагаа өрнүүлэх, судалгаа хийх.	Судалгааны ажлын тоо	Тухайн байгууллагын өнөөгийн түвшин	1-р улиралд: Ажлын цар хүрээгээ тогтоож, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхэлсэн байна. 4-р улиралд: Нийтдээ 2-оос доошгүй судалгааны ажлын эцсийн тайланг яаманд танилцуулсан байна.	I-IV улирал	ЗУХ
3.2.12	Өөрсдийн чиг үүргийн хүрээнд цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах.	Хэрэгжилтийн байдлаар	Тухайн байгууллагын өнөөгийн түвшин	Тухай бүр цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байна.	I-IV улирал	ЗУХ
ЗОРИЛТ 3.3 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх						
3.3.1	Ажилтнуудыг салбарын олон улсын хурал, зөвлөгөөнд хамруулах	Ажилтнуудыг холбогдох хурал, зөвлөгөөнд	2021 онд салбарын 7 хурал, зөвлөгөөнд нийт 10 ажилтанг хамруулсан.	1-4-р улиралд: Хурал, зөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан байна.	I-IV улирал	ЗУХ




		хамруулсан байна.				
3.3.2	Ажилтнуудыг салбарын олон улсын сургалт, семинарт хамруулах	Ажилтнуудыг холбогдох олон улсын сургалт, семинарт хамруулсан байна	2021 онд далайн тээврийн салбарын нийт 8 сургалт, семинарт 11 ажилтныг хамруулсан байна.	1-4-р улиралд: Холбогдох мэргэжилтнүүдийг олон улсын сургалт, семинарт хамруулсан байна.	I-IV улирал	ЗУХ
3.3.3	Далайн салбарын байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгүүдийн дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	Санамж бичигт тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажилласан байна.	Монгол Улсын Далайн захиргаа БНСВУ-ын Далайн захиргаа, БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт, ОХУ-ын Адмирал Г.И.Невельскойн нэрэмжит Тэнгисийн их сургуультай тус тус Санамж бичиг байгуулсан.	2-р улиралд: Санамж бичгийн хүрээнд 2022 онд хамтран хэрэгжүүлэх боломжит арга хэмжээний саналыг боловсруулан хамтран ажиллагч байгууллагуудад хүргүүлсэн байна. 4-р улиралд: Санамж бичгийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллагч байгууллагатай харилцан санал солилцож санамж бичгийн хүрээнд боломжит арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.3.4	Бусад улсын далайн салбарын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Монгол Улсын Далайн захиргаатай ижил түвшний байгууллагуудтай шинээр холбоо тогтоож, хамтран ажиллах санал хүргүүлсэн байна	Монгол Улс ОУДБ болон Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын удирдлагуудын зөвлөл (APhOMSA)-ын гишүүнээр элсэн орсон.	2-р улиралд: Хамтран ажиллах боломжтой байгууллагын судалгааг хийж, хамтран ажиллах саналыг хүргүүлсэн байна. 4-р улиралд: Холбоо тогтоож хамтран ажиллах боломжийг эрэлхийлсэн байна.	I-IV улирал	ЗУХ
3.3.5	Ази, Номхон далайн бүс нутгийн Далайн тээврийн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагуудын зөвлөлийн ээлжит 22 дугаар зөвлөгөөнд оролцох	Зөвлөгөөнд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан байна.	Монгол Улс Ази, Номхон далайн бүс нутгийн Далайн тээврийн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагуудын зөвлөлд 2018 онд гишүүнээр	2-р улиралд: Ази, Номхон далайн бүс нутгийн Далайн тээврийн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагуудын 22 дугаар зөвлөгөөнд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулах арга хэмжээг авсан байна.	II улирал	ЗУХ



			элссэн. Зөвлөгөөнд жил бүр оролцож ирсэн.			
ЗОРИЛТ 3.4 Далайн захиргааны 2022 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах						
3.4.1	Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын аудитын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах	Аудитын төлбөрийг төлж барагдуулсан байна.	Хөлөг онгоцны байршил тогтоох, алсын зайнаас хянах байгууллагатай гэрээ байгуулсан.	3-р улиралд: Аудитын тайланг үндэслэн аудитын төлбөрийг төлж барагдуулсан байна.	III улирал	ЗУХ
3.4.2	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлэх	Улсын төсөвт батлагдсан хуваарийн дагуу 230 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.	2021 онд улсын төсөвт 230 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж ажилласан байна.	1-4-р улиралд: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хуваарийн биелүүлсэн байна.	I-IV улирал	ЗУХ, ХОБХА
3.4.3	Далайн захиргааны 2022 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгагдсан урсгал зардлын гүйцэтгэл, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж, тайлагнах, зарцуулалтад хяналт тавих	Далайн захиргааны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг хуваарийн дагуу биелүүлсэн байна.	2021 оны гүйцэтгэл, төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж, дүгнүүлэв.	1-4-р улиралд: Орлого, зарлагын төлөвлөгөөний биелэлт хуваарийн дагуу хангагдсан байна.	I-IV улирал	ЗУХ
3.4.4	Үндэсний аудитын газар болон бусад хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах	Албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.	2020 оны Үндэсний аудитын газраас ирүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг хуулийн хугацаанд хэрэгжүүлж тайлагнав.	4-р улиралд: Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн тухай албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	IV улирал	ЗУХ
3.4.5	"Төсвийн тухай хууль", Шилэн дансны тухай хуулийн дагуу санхүүгийн гүйлгээг сар, улирал, хагас, бүтэн жил тутам ил тод мэдээлж байгаа байдалд хяналт тавьж, цахимаар	Далайн захиргааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгагдсан ажил гүйлгээний талаарх мэдээллийг ил	Тухайн жилийн санхүүгийн гүйлгээг сар, улирал, хагас, бүтэн жил тутам ил тод мэдээлж байгаа байдалд хяналт тавьж, цахимаар Сангийн	1-4-р улиралд: Сар, улирал, бүтэн жилээр 100 хувь ил тод мэдээлж ажилласан байна.	I-IV улирал	ЗУХ



	Сангийн яаманд хүргүүлж, баталгаажуулах	тод байршуулсан байна.	яаманд хүргүүлж ажилладаг.			
3.4.6	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааг ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах	Худалдан авах ажиллагааг Далайн захиргааны үйл ажиллагааны орлого, зарлагын батлагдсан төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан байна	Худалдан авах ажиллагааны тайланг улирал бүр ЗТХЯ-нд хүргүүлж хэвшсэн.	1-4-р улирал: Тухайн онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааг улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар ЗТХЯ-нд тайлагнасан байна.	I-IV улирал	ЗУХ
ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХАД ЧИГЛЭСЭН ЗОРИЛТ						
ЗОРИЛТ 4.1 Далайн болон усан замын тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн зөвлөгөөгөөр ханган дэмжлэг үзүүлж ажиллах.						
4.1.1	Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ, улсын дугаар олгох, шилжилт, хөдөлгөөн хийх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэх	Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүндрэл чирэгдэлгүйгээр үзүүлсэн байна.	2021 оны байдлаар улсын бүртгэлд нийт 147 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийлгэсэн 7, шинээр 2 тээврийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээ, улсын дугаар олгосон.	1-4-р улиралд: Шаардлагатай мэдээллээр хангаж, ирүүлсэн хүсэлт өргөдлийг шийдвэрлэж, бүртгэлийн тайлан, мэдээг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	I-IV улирал	УЗТБХА
4.1.2	Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдэд зориулан "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт семинарыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулах	Сургалт, семинарыг зохион байгуулж, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хамруулсан байна.	Усан замын тээврийн хөвөлтийн улирал эхлэх үед хамтарсан семинарыг жил бүр Хөвсгөл аймгийн Хатгал тосгон болон Архангай аймгийн Өгийнуур суманд зохион байгуулдаг.	3-р улиралд: Сургалт, семинарыг зохион байгуулж, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хамруулсан байна.	III улирал	УЗТБХА



4.1.3	Монгол Улсын экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг хөрш орнуудын боомтоор дамжуулан тээвэрлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд оролцогч байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын зөвлөлдөх уулзалт, ярилцлага зохион байгуулах	Зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан байна.	“Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ-тай 2018 онд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд жил бүр зохион байгуулахаар тусгагдсан.	4-р улиралд: Семинар хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгуулсан байна.	IV улирал	ДТБАХА
4.1.4	ШУТИС-ийн Механик, тээврийн сургуульд мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Далайн тээвэр, боомт ашиглалт” сэдэвт хичээлийг хөтөлбөрийн дагуу оюутнуудад зааж хамтран ажиллах	“Далайн тээвэр, боомт ашиглалт” сэдэвт 32 цагийн хичээлийг тус сургуулиас батлан гаргасан хөтөлбөрийн дагуу оюутнуудад зааж хамтарч ажилласан байна.	ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай хамтын ажиллагааны Санамж бичгийг 2018 онд байгуулсан. Тус сургуулиас тавьсан хүсэлтийн дагуу оюутнуудад 2020-2021 онд “Далайн тээвэр, боомт ашиглалт” сэдвээр хичээл зааж хамтран ажилласан.	1-2-р улиралд: “Далайн тээвэр, боомт ашиглалт” сэдэвт хичээлийг тус сургуулийн оюутнууд сонгон суралцах тохиолдолд хуваарийн дагуу заасан байна.	I-II улирал	ДТБАХА

---oOo---



Далайн захиргааны 2022 оны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт

2021.12.30

№	Үйл ажиллагаа	Суурь үзүүлэлт /2021 он/	Төлөвлөсөн /2022 он/	Гүйцэтгэл	Чанарын үзүүлэлт /харьцуулалт/	Тайлбар
1. Эдийн засгийн үзүүлэлт						
1.1.	Нийт орлого	1,500,000,000	-			
1.1.1.	Хөлөг онгоцны бүртгэлийн орлого	1,500,000,000	-			
1.1.2.	Сургалтын орлого	0	0			
1.2.	Нийт зардал	1,300,000,000	1,500,000,000			
1.2.1.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой зардал	28,000,000	40,000,000			
1.2.2.	Үйлчилгээг цахимжуулахтай холбоотой зардал	6,900,000	50,000,000			
1.2.3.	Судалгааны зардал	0	0			
1.3.	Ашиг, алдагдал	380,000,000	-			
1.4.	Хөрөнгө оруулалт	0	0			
2. Нийгмийн үзүүлэлт						
2.1.	Нийт ажилчдын тоо	24	24			
2.1.1.	Захиргааны	12	12			
2.1.2.	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой	12	12			
2.1.3.	Эрэгтэй	13	13			
2.1.4.	Эмэгтэй	11	11			
2.2.	Ажилчдын шилжилт хөдөлгөөн	14	-			
2.3.	Ажилчдын дундаж цалин	1,635,000	1,635,000			
2.4.	Хөдөлмөрийн бүтээмж	100%	100%			
2.5.	Ажилчдын мэргэжил дээшлүүлсэн байдал	5	-			
2.6.	Ажилчдын нийгмийн асуудлыг шийдсэн байдал	6	-			
2.7.	Авлига ашиг сонирхолтой холбоотой үзүүлэлт	0	0			
3. Хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үзүүлэлт						
3.1.	Үйлдвэрлэлийн ослын тоо	0	0			
3.1.1.	Үйлдвэрлэлийн осолд өртсөн хүний тоо	0	0			
3.1.2.	Нийт хурц хордлогын тоо	0	0			
3.2.	Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал	0	1			
3.3.	Ажилчдын ажлын байрны аттестатчлал, хөдөлмөрийн нөхцөл сайжруулалт	0	-			
4. Аюулгүй ажиллагаатай холбоотой үзүүлэлт						
4.1.	Нийт гарсан осол, гологдол, сүйрэл	0	0			
4.1.1.	Усан замын тээвэрлэлтэд гарсан	0	0			
4.1.2.	Далай ашиглалтын үйл ажиллагаанд гарсан	0	0			
5. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлт						
5.1.	Зорчигч тээвэрлэлт	24,707	5%			
5.2.	Ачаа тээвэрлэлт	0	0%			
5.3.	Тухайн жилийн бүртгэгдсэн хөлөг онгоцны тоо	105	50			
5.4.	Тухайн жилийн улсын төсөвт төвлөрүүлсэн орлого	230,000,000	230,000,000			
5.5.	Тухайн жилийн зохион байгуулсан сургалтын тоо	1	1			

